

## БОЛОВСРОЛЫН ЗЭЭЛИЙН САНГИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН 2026 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2025 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/96 тоот Ажлын албаны даргын тушаалаар байгууллагын бүтэц 32 байхаар батлагдсан. 2026 оны 6 сарын 24-ний өдрийн байдлаар нийт 28 (хүний нөөцийн бүрдүүлэлт 87,5%) албан хаагчтай ажиллаж байна.

**Хүний нөөцийн томилгоо:** 2026 оны хагас жилийн байдлаар нийт 3 удаа сонгон шалгаруулалт зарлаж ажилласан. Тус хугацаанд Захиргаа, удирдлагын хэлтэст Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн 1, Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэст Гадаад зээл, тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн 3, Дотоод, зээл, тэтгэлгийн хэлтэст Дотоод зээл, тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн 1 нийт 5 албан хаагчийг ажилд томилсон байна.

Зарлагдсан ажлын байр			Сонгон шалгаруулалтын хамрах хугацаа: 2026.01.01-2026.06.30				
	Хэлтэс	Албан тушаал	Зарлагдсан тоо	Зар нийтэлсэн хугацаа	Материал хүлээн авсан хугацаа	Хүлээж авсан материалын тоо	Томилгоо
Сонгон шалгаруулалт 1	Санхүүгийн хэлтэс	Ерөнхий нягтлан бодогч	1	2026.01.22	2026.01.26	4	Шаардлага хангасан ажил горилогч байхгүй
	Захиргаа, удирдлагын хэлтэс	Хүний нөөц, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	1			5	1
	Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтэс	Дотоод зээл, тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	1			3	1
	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	1			4	1
Сонгон шалгаруулалт 2	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	2	2026.03.13	2026.03.18	30	2
Сонгон шалгаруулалт 3	Санхүүгийн хэлтэс	Ерөнхий нягтлан бодогч	1	2026.03.06	2026.03.12	5	Шаардлага хангасан ажил горилогч байхгүй
<b>Нийт</b>							<b>5</b>

**Ажлаас чөлөөлөх:** тус хугацаанд нийт 4 албан хаагчийн өөрийн гаргасан өргөдлийг үндэслэн чөлөөлсөн байна. Үүнд:

№	Хэлтэс	Албан тушаал	Ажлаас чөлөөлөх шалтгаан	Ажлаас чөлөөлсөн албан хаагчийн тоо

1	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	Өөрийн хүсэлт	1
2	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан ахлах мэргэжилтэн	Өөрийн хүсэлт	1
3	Дотоод зээл, тэтгэлэг, буцалтгүй тусламжийн хэлтэс	Дотоод зээл, тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	Өөрийн хүсэлт	1
4	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	Өөрийн хүсэлт	1
<b>Нийт</b>				<b>4</b>

**Туршилтын хугацаа:** туршилтын хугацаанд ажиллаж байгаа албан хаагчийн мэдээлэл

№	Хэлтэс	Албан тушаал	Туршилтын хугацаа дуусах өдөр	Туршилтын хугацаа сунгасан мэдээлэл
1	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	2026.06.19	1 удаа 1 сарын хугацаагаар
2	Гадаад зээл, тэтгэлгийн хэлтэс	Гадаад зээл тэтгэлэг хариуцсан мэргэжилтэн	2026.06.30	Туршилтын тайлан хэлэлцэж байна
<b>Нийт</b>				<b>2</b>